

Манмин Мэдээ

№ 63 2018 оны 8 сарын 26

“Анагаах ухаанаар Бурханы эрх мэдэлт хүч нөлөөг нотлох үйлчлэл”

Польшд болж өнгөрсөн WCDN 15 дах удаагийн конференцд дэлхийн 17 улс орноос 400 гаруй эмч нар оролцлоо.



2018оны 6-р сарын 16-17 ны хооронд Польш улсын нийслэл Варшавд “Ариун Сүнний үйлс, Анагаах ухаан, Шинжлэх ухаан” сэдвийн дор WCDN (Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбоо)-ны 15 дах удаагийн олон улсын конференц болж өнгөрлөө. WCDN (Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбоо) нь Бурханы эрх мэдэлт хүчээр өвчин эдгэрсэн баримтуудыг анагаах ухааны үүднээс баталж нотлох дэлхийн даяарх эмч нарын нэгдсэн холбоо нь жил бүр дэлхийн улс орнуудад ээлжлэн олон улсын конференц явуулдаг уламжлалтай болжээ.

Энэ удаагийн конференцд Израйль, ОХУ, Испани, Итали, Болгари зэрэг 17 н орны 400 гаруй эмч нар болон анагаах ухаан судлаачид оролцож, англи, польш, орос, испани хэл дээр шууд орчуулагдаж байлаа. Хоёр өдрийн турш нийт 12 төрлийн эдгэрлийн баримтыг танилцуулж, 4 илтгэл болон семинар болж өнгөрлөө.

Магтаал ба хүндэтгэл, оролцож буй орон болон зочдыг танилцуулсаны дараа зохион байгуулах хорооны дарга доктор Дариа Вожнар хатагтайн нээлтийн мэндчилгээний үг хэлж уг үйл ажиллагаа албан ёсоор эхэлж, хамгийн эхэнд Андрей Гажировский (WCDN Израйль захирал) доктор илтгэл тавив. WCDN (Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбоо)-г үүсгэн байгуулагч И Жей руг пасторын амьдрал, түүний үйлчлэлийн тухай мөн тэрээр өөрөө Солонгост очоод

уулзсан тухай зэрэг И Жей руг пасторын тухай танилцуулсан юм.

Тэрээр “Энэ конференцд бэлдэж байхдаа олон анагаах ухааны хүмүүстэй уулзсан бөгөөд тэд бүгдээрээ гайхан биширч Бурханы эрх мэдэлт хүчний талаар ярина гэдэг их чухал гэлцэж байв. Тиймд би И Жей руг докторын залбирлаар эдгэрсэн олон баримтууд болон түүний Бурхан болон Эзэний төлөө, хүмүүсийн төлөөх амьдралыг гэрчилнэ гэдэг нь итгэгч эмч нарт их сэтгэл хөдөлгөөсөн үйл явдал гэж бодож байна. Ийм ч учраас би өөрийнхөө харсан мэдэрсэн, уулзаж үзсэн И Жей руг докторын үйлчлэл, даруу төлөв байдал, хайрын тухай илтгэл тавихаар бэлдсэн юм” гэж ярьсан юм.

Үргэлжлүүлэн WCDN-ны захирал Чэ Юун сог докторын мэндчилгээ болон И Жей руг пасторын хүчит үйлчлэлийн тухай видео танилцуулга үзүүлсэний дараа эдгэрлийн гэрчлэлийн тухай илтгэлдээ орсон юм. Энэ жил И Жей руг пасторын залбирлаар эдгэрсэн Солонгосын болоод гадаад итгэгч нарын 7 гэрчлэлийг танилцуулсан юм.

Любка Танчева (Болгари) доктор нь цус харвалтын тухай, Олесса Танас (Молдави) докторын атгаал яс, бугалгын ясны хугаралын эдгэрэл, Даниел Пуеинтэс (Мексик) доктор цөсний хүүдий үрэвсэл өвчний эдгэрэл, Бахе Буниатан (Армени) докторын зүрхний шигдээс өвчнөөс эдгэрсэн тухай, Ким Жүн сон (Солонгос) докторын нүдний

хараа сэргэсэн тухай байсан бол ялангуяа Ян Чан гю (Солонгос) докторын муу ёрын сүнснээс чөлөөлөгдсөн тухай баримт нь сүнс талын ертөнцийн тухай гүн гүнзгий мэдээлэл өгч, анагаах ухаанаар эдгээх, өвчин намдааа төдий бол сүнс талын асуудлыг шийдэж өгвөл төгсүзү эдгэрэл олох боломжтой гэсэн баталгааг үзүүлж өгсөн явдал боллоо.

Түүнчлэн Девид Юу (Сингапур) докторын ‘Мүаны амтат ус’-р эдгэрсэн тухай гэрчлэл олны анхаарлыг татаж байлаа. Марагын шорвог ус амтлаг усаар өөрчлөгдсөн (Е. гарсан нь 15:25) шиг И Жей руг пасторын залбирлаар Мүан манмин сүмийн урд байх далайн эрэг дэх шорвог ус амтлаг ус болон хувирч, өвчин эдгээх төдийгүй, үхэж байсан ургамал сэргэх зэрэг эрх мэдэлт хүчний үйлс илчлэгдээр байгаа юм.

Үүээс гадна Польшийн эмч нар анагаах ухаан болон зуучлан залбирлаар эдгэрсэн гэдэсний дотоод гялтан хальсны үрэвсэл, хөхний хорт хавдар, тархинд цус харвалт, өнчин тархины булчирхай дах хавдар, төрөхийн гажиг зэрэг 5 төрлийн баримтыг дэлгэн танилцуулсан юм. Хоёр дах удаагийн илтгэл дээр DVD видео баримт дээр тулгуурласан И Жей руг пасторын сургаал дээр тулгуурласан ‘Амийн үр’ үзүүлэнг танилцуулсан бол гурав дахь илтгэл дээр Чэ Юун сог докторын ‘Өвчний учир шалтгаан’ сэдэвт илтгэл тавигдсан юм.

Дмитри Крупин (Украин) эмч “Бурханы хүчийг анагаах ухаантай

нэгтгэж, учир шалтгааныг тайлбарлана, нотлоно гэдэг үнэхээр гайхалтай үйл явдал юм. Илтгэлүүдээр дамжуулан өвчний асуудлыг шийдэх арга нь сүнс тал дээр ч арга барил байдагыг ухаарсан цаг байлаа” гэж байлаа. Хамгийн сүүлийн илтгэлийг Даниел Ружен (WCDN Ойрхи дорнодын кординатор) пастор нь ‘Израйлийн өнгөрсөн, одоо, ирээдүй’ гэсэн сэдвээр тавьсан юм.

Энэ удаагийн конференцийн зохион байгуулах хорооны дарга доктор Дариа Вожнар “Залбирлаар дамжуулан илрэн гарах Бурханы эдгээх хүчит үйлсийн тухай сонсох нь үнэхээр гайхалтай ивээлтэй үйл явдал байлаа. Төрөл бүрийн эдгэрлийн гэрчлэл баримтаар сүнс талаар өсгөж ухааруулж өгсөн илтгэлүүд, сэтгэл хөдлөм урлагын тоглолт зэрэг үнэхээр гайхамшигтай байлаа. Ийм гайхалтай боломжыг нээж өгсөн И Жей руг доктордоо гүн талархал илэрхийлье.”

Нөгөө талаар манай сүмийн урлагын багийн тоглолт нь тухайн улсын хэлээр төдийгүй нийт 6 орны хэлээр магтаал болон бүжиг, мөн Польш ардын үндэсний бүжиг зэрэг чадварлаг үзүүлбэрүүд сэтгэл хөдөлгөм байлаа. Мөн уг үйл ажиллагаа болж буй газрын үүдэнд бэлдэн тавьсан буланд Загалмайн Үг, Тэнгэрийн орон, Там зэрэг И Жей руг пасторын итгэлийн амьдралд зориулсан ном хэвлэлийн үзэсгэлэн худалдааг сонирхсон хүмүүсийн хөл тасарахгүй байлаа.

Эдгээгч Бурхан



Манмин төв чуулганы тэргүүн пастор,
И Жей руг пастор

- Есүс Христийн нэгдсэн ариун урсгалын ерөнхий удирдагч
- Христийн сайн мэдээ сэргэлтийн холбооны ерөнхийлөгч
- Үндэсний хайрын залбирлын нэгдсэн хорооны хамтын удирдагч
- (GCN) (Жи Си Эн) Глобал Христийн телевизийн ерөнхий захирал
- (WCDN) Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбооны ерөнхий захирал
- (MIS) Манмин олон улсын библийн их сургуулийн захирал
- Нэгдсэн ариун библийн сургуулийн захирал
- Библи судлалын доктор, Теологийн хүндэт доктор
- Христийн телевиз, радиогийн албан ёсны сургаал заагч
- Чусон илбу, Жүнан илбу, Туна илбу, Хангүг илбу, Сөүл сонин Хангёорэ сонин, Кёонхян сонин, Хангүг кёнжэ сонин, Ши са ньюс, Кристиан сонин зэрэг өдөр тутмын сонин, сэтгүүлд итгэлийн амьдралын тухай байнгын нийтлэгч
- АНУ-н Нью-Йорк, Вашингтон, Балтимор, Мерилэнд, Лос-Анжелос, Хавай, Япон, Пакистан, Филиппин, Аргентин, Гондурас, Перу, ОХУ, Герман, Кени, Танзани, Уганда, Конго бүгд найрамдах улс, Израйль Иерусалим, Эстони зэрэг улс орнуудад нэгдсэн их цуглааныг удирдан явуулсан

Өчигдөр ч өнөөдөр ч хэвээр орших Бурхан өнөө үед ч хайрт үр хүүхдүүдээ өвчин зовлонгоос хамааралгүй эрүүл энх амьдрахыг хүсэж байдаг билээ. Уг үндэс эхлэл байхгүй бол эцсийн үр дүн байдаггүй шиг бүх өвчин шаналалд ч уг шалтгаан байдаг тул тэр уг үндэсийг нь мэдвэл өвчнөөсөө эдгэрэх нь хэцүү зүйл биш юм. Тэгвэл өвчний уг шалтгаан нь юу болдог, яавал эдгээгч Бурхантай уулзах вэ?

1. Бурханы хүсэж буй 'Итгэл' хэмээх сав бэлдэх

Есүсийн үйлсийг тэмдэглэн үлдээсэн сайн мэдээний 4 н номд үзвэл Есүсийн явж буй газар бүрт хараагүй хүн хараатай болж, сонсголгүй хүн сонсдог болж, суумгай нь босож харайдаг болж уяман өвчин төдийгүй төрөл бүрийн өвчнөөсөө эдгэрч, тэр ч байтугай үхсэн хүн ч дахин амьдарсан байдаг.

Энэ мэтчилэн Есүс агуу эрх мэдэлт хүчийг үйлдсэн ч бүх хүмүүс дээр дурьдсан шиг эдгэрээгүй юм. Бурханы хүсэж буй итгэл байна уу үгүй юу гэдгээс шалтгаалж, эцсийн үр дүн нь өөр байсан юм. Есүс дээр итгэлээрээ очсон хүмүүс юу ч гуйсан тэрчлэн хариултаа авч байлаа (Матай 9:18-26; Марк 10:46-52). Заримдаа өөрийн биеэр очиж чадаагүй ч гэрийнх нь өмнөөс нь очиж итгэлээрээ гуйж хариулт аван Бурханд алдрыг өргөж байлаа.

Марк номын 2-р бүлэгт гарах нэгэн саа өвчтөнийг найзууд нь Есүс дээр аваачихдаа олон хүн цугласан тул орох боломжгүй байсан ч Есүсний байсан газрын дэврийг цоолж, саа өвчтэй найзаа хэвтэртэй нь доош буулгасан юм. Есүсийн өмнө очиж л байвал эдгэрэх болно гэсэн итгэлтэй байсан учраас юм. Есүс түүний итгэлийг харж, саа өвчтөнг босож алхдаг болгон эдгээж өгсөн юм. Үүнчлэн бүтээгч Бурханы хүч нөлөөг авахын тулд зайлшгүй итгэл гэх савийг бэлдэх хэрэгтэй

Дэлхийн шинжлэх ухаан, анагаах ухаанаар элдэв хүнд өвчин, эдгэршгүй, найдваргүй гэгдэх өвчнүүд ч Бурханы хүч чадлаар ямар ч өвчин байсан эдгэрэх боломжтой юм. Тэргэнцэр дээр ирсэн бол ганцаараа алхдаг болж, хараагүй нүд хардаг болж, хэлгүй нэгэн ярьдаг болж, хичнээн амийн аюултай байсан ч итгэлээрээ залбирал авбал эргэн хэвийн болох боломжтой юм. Ийм Бурханы хариултыг авахын тулд юу юунаас илүү өвчний уг шалтгааныг сайн мэдэх ёстой.

2. Өвчний учир шалтгаан

1) Гэм нүглийн улмаас

Бурхан өнөө эртнээс тэнгэр газрыг бүтээх үед энэ дэлхийд өвчин зовиур, гамшиг, үхэл гэх зүйл байхгүй байлаа. Гэтэл анхны хүн Адам гэм үйлдэн Едэн цэцэрлэгээс энэ газар руу хөөгдсөний дараа бүх түмэн бодис хараал хүртэж өвчин үүсгэгч, бактери, вирус өвчин халдах бохир зүйлүүд бий болсон байдаг. Орчны бохирдолын улмаас өвчин үүсч төрөлхийн болон олдмол эд эс эрхтэний тогтолцоо суларч, сул дорой гаж хөгжил зэрэг бий болсон юм. Эцэст нь Адамын гэмт үйлс бүх л өвчний уг үндсэн шалтгаан болсон юм.

Египетээс гарсан нь 15:26д "...Түүний бүх тогтоолыг сахвал, Би египетчүүдэд буулгасан өвчнүүдээс нэгийг нь ч та нарт буулгахгүй..." гэсэн бөгөөд өвчний

уг шалтгаан нь гэм нүгэл болохыг ухааруулж өгсөн байдаг. Бурханы үгийн дагуу амьдарвал ямар ч өвчин тусалгүй сахин хамгаалагддаг юм.

Иохан номын 9-р бүлэгт гардаг төрөлхийн хараагүй нэгэн мэт өөр учир шалтгаантай зүйл байдаг ч ихэнх тохиолдолд гэм нүгэлтэй шууд холбоотой бөгөөд эхлээд гэмийн асуудлыг шийдэх хэрэгтэй юм. Есүс ч гэсэн хүмүүсийн өвчнийг эдгээхийн өмнө эхлээд гэмийн уучилж өгдөг харж болох юм (Марк 2:5). Юуны өмнө Бурханы үгийн дагуу амьдарч чадаагүй зүйлээ ухаарч гэмших ёстой юм.

2) Биеийн ачаалал, тэнцвэрт байдлыг алдагдуулах тохиолдол

Өөрийн биеийг хайхаралгүй эрүүл мэндэд хохирол учруулж болох үйлдлүүдийн улмаас бие өвчлөх нөхцөл бүрддэг. Биеийн ачаалал хэтрүүлэн ямар нэг зүйлд улайрах, буруу хооллолт, хэт их идэх, гэх зэрэг биед хэрэгцээтэй шим тэжээл бүрэн аваагүй улмаас. Мөн архи согтууруулах ундаа, тамхи зэрэг биед хортой зүйлийг ихээр хэрэглэх. Биед муу, хортой гэдгийг нь мэдсээр байж, шунаг хүслээ дийлж чадахгүй хорт муу зуршлууд, биеэ бодох ажил амралтын хуваарь алдагдуулсан тохиолдлууд юм. Энэ ч мөн Бурханы тогтоож өгсөн хүний биеийн зүй тогтолыг алдагдуулах тул хамгаалагдаж чадахгүй юм.

Бурханы өгсөн бие махбодийг эрхэмлэн, ариунаар сахин хамгаалах, гамнаж мэдэх хэрэгтэй юм. Түүний дараа ийм тохиолдолд эдгэрэхийн тулд Бурханы өмнө зохистой үйлдэж чадаагүйдээ гэмших ёстой.

3) Мэдрэлийн болон сэтгэцийн үйл ажиллагаатай холбоотой тохиолдол

Удаан хугацааны санаашрал, сэтгэл зовиураас үүдэлтэй эсвэл хүнд хэлбэрийн стрессийг үргэлжлүүлэн авах, огцом хүчтэй уурлах, үзэн ядах, уйтгарлах зэрэг түүнчлэн эдгээр хүчлэн тэвчих үед өвчилж болох юм. Мэдрэлийн невроз, ганихрал, уурламтгай, мэдрэл болон сэтгэцэд нөлөө үүсч биеийн бусад эрхтэнүүдэд асуудал үүсэх болдог. Сэтгэцийн хувьд сул дорой бодолд автсанаар харанхуйн нөлөөнд ч автаж болзошгүй болдог.

"Юунд ч бүү санаа зов. Харин аливаа зүйлд залбирлаараа болон гуйлтаараа талархалтайгаар хүсэлтээ Бурханд мэдүүл" (Филиппой 4:6), "Үргэлж баяртэй бай, Тасралтгүй залбир, Бүх зүйлд талархалаа илэрхийл" (1 Тесалоник 5:16-18), "Бүх хүнтэй эвтэй байхыг болон ариусгалыг мөшгөгтүн" (Еврей 12:14) зэрэг үгийн дагуу амьдарвал ийм өвчнүүд тусахгүй юм.

Мөн миний сэтгэлд үзэн ядалт, уур хилэн сэтгэл тавгүйтэл байгаа учир бусдыг уучилж чадалгүй гоморхож, үзэн ядах болдог. Талархаж чадахгүй, баяр хөөртэй байж чадалгүй, тавгүйтэж уйтгарлан гэдэг нь Бурханд найдан түшиглэдэггүй учраас юм. Эцэст нь Бурханы харахад зөвийг үйлдэж чадахгүй тул гэмших ёстой юм.

4) Дайсан сатаны улмаас өвчлөх тохиолдол

Энэ нь сатанд эзэмдүүлэх юмуу муу ёрын сүнсэнд хөтлөгдөх байдлыг хэлэх бөгөөд бие болоод сэтгэцийн саатал, гэх мэт өвчнүүдийн дундаас сатаны өгдөг өвчин гэж бий. Ихэнхдээ хиймэл шүтээн их шүтдэг

Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг
Утас: 88107327, 91170773, 89737773

www.manmin.org
www.gcntv.org

“Тэр-Хэрэв та нар өөрсдийн Бурхан ЭЗЭНий дуу хоолойг анхааралтай сонсож, Түүний мэлмийд зөвийг үйлдэж, Түүний тушаалуудад чих тавьж, Түүний бүх тогтоолыг сахьвал, Би египетчүүдэд буулгасан өвчнүүдээс нэгийг нь ч та нарт буулгахгүй. Учир нь ЭЗЭН Би бол та нарыг эдгээгч билээ гэв” (Египетээс гарсан нь 15:26).

гэр бүлд их тохиолдох ба ийм гэр бүлд янз бүрийн бэрхшээл, зовлон тасардаггүй болохыг ажиглаж болно. Өвчин зовлон, тахир дутуу байдал, сэтгэцийн өөрчлөлттэй, архинд донтох, ганихрал, амиа хорлолт зэрэг гай зовлон тасардаггүй (Е. гарсан нь 20:4-5).

Хэдий ийм гэр бүл ч Бурханы үгийн дагуу амьдарвал хамгаалагдах боломжтой юм. Гэтэл өөрөө ч мэдэлгүй хиймэл шүтээнтэй холбоотой бол хор уршиг нь хэвээр үлдэх тохиолдол их бий. Эцэн эх нь өөрсдийн өвөг дээдэс болон хиймэл шүтээнтэй холбоотой зүйлд өөрсдийн нэрийг сийлсэн бичсэн тохиолдолд нэрээ арилгах, баллах хэрэгтэйг анхаарах хэрэгтэй. Ийм уяаг тастаж хаяснаар итгэлээрээ өвчнөөсөө чөлөөлөгдөх боломжтой юм.

Үүнээс гадна өөрөө дэндүү их хорон мууг үйлдсэн үед сатанд эзэмдүүлэх, муу ёрын сүнсний нөлөөг авч болзошгүй болдог. Итгэдэг мөртлөө муу сүнсний нөлөөг авдаг бол энэ дэндүү хорон мууг үйлдэж, тодорхой хязгаарыг давсан гэж ойлгож болох юм. Хэрэв өөрийн сэтгэцийн байдал хэвийн бус, өөрөө сургаал сонсож чадалгүй гэмших чадваргүй бол, өөрөө сүмд ирэх бус гэр бүлийнх нь өмнөөс нь хайраар чин сэтгэлээсээ гэмшиж, итгэлээрээ ирж эрх мэдэлт хүчтэй залбирлыг авах хэрэгтэй юм.

3. Өвчин эдгээх арга

1) Бурханы өмнө халхласан гэмийн ханыг хурдан нураах ёстой

Исаиа 59:1-2д “Үзэгтүн, Эзэний мутар аварч чадахааргүй богино бишээ. Түүний чих сонсож чадахааргүй дүлий биш ээ. Харин та нарын гэм буруу нь та нарыг Бурханаас хагацуулан, та нарын нүглүүд Бурханы нүүрийг та нараас далдалжээ. Тийм учраас Тэр сонсдоггүй.” гэсэн байдаг. Энэ нь Бурхан ба хүний хооронд хаагдсан гэмийн ханын улмаас хариулт авч чаддаггүй тул Бурханы хүч нөлөөг авмаар байвал эхлээд өөрийн гэмийг чин сэтгэлээс гэмшин, эргэж, гэмийн ханыг нураах хэрэгтэй юм.

Нэгдүгээрт, Бурханд итгэлгүй Есүс Христийг хүлээн аваагүйдээ гэмших хэрэгтэй.

Биднийг бүтээсэн бүтээгч Бурхан, биднийг хайрлан цорын ганц Хүүгээ хүртэл эвлэрүүлэл

болгон өргөсөн юм (1 Иохан 4:10). Ийм хайрыг ухаарч мэдээгүй, итгээгүй гэдэг гэм нүглийн дундаас том гэм юм.

Бурхан бол амьд оршин байгаа бөгөөд бид залбирч гуйхад хариу өгч, эдгээж өгдөг гэдгийг ухаарч Бурханд итгээгүй, Есүс Христийг хүлээн аваагүйдээ гэмших хэрэгтэй юм. Түүнчлэн Эзэнийг хүлээн аваад Ариун Сүнснийг бэлгээр хүлээн авбал Ариун Сүнсний галаар бүх сул дорой байдал шатаагдан асар хурдан төгс цэвэр болох тохиолдол их байдаг.

Хоёрдугаарт, Хэдийн Эзэнийг хүлээн авсан ч жинхэнэ итгэлтэй байж чадаагүйгээ гэмших хэрэгтэй.

Итгэдэг гэсэн ч бүх зүрх сэтгэлээрээ Бурханд баттай итгэж чаддаггүй, Эзэнийг аврагч Эзэн гэж итгэдэггүй тохиолдол юм. Ийм хүн ямар нэг асуудал тулгарвал Бурханд түшиглэхээс илүү ертөнцийн аргад илүү их найддаг (Шастирын дэд 16-р бүлэг).

Бүхнийг чадагч Бурханд итгэдэг бол мэдээж Бурханд бүх талаар түшиглэдэг. Ертөнцийн арга чарга хэрэглэнэ гэдэг нь тэр хэмжээгээр Бурханд итгэж чадахгүй байгаа шинж юм. Мөн төгс итгэж чадахгүй байгаад гэмшиж, эцсээ хүртэл зөвхөн Бурхандаа түшиглэж, итгэлээ үзүүлвэл Бурхан зайлшгүй хариулж өгдөг юм.

Гуравдугаарт, Бурханы хуулийг сахиж чадаагүйдээ гэмших хэрэгтэй.

Бурханыг хайрлан гэдэг нь Түүний тушаалуудыг сахих явдал (1 Иохан 5:3) гэсэн бол, Эзэнээс эмээхүй бол хорон мууг үзэн ядах явдал (Сургаалт үгс 8:13) гэсэн байдаг. Бурханд итгэдэг, хайрладаг, хүндэлдэг, эмээдэг гэсэн мөртлөө гэм нүгэл дотор амьдардаг худалч гэсэн байдаг (1 Иохан 2:4). Библид “Хий”, “Бүү хий”, “Сахь”, “Хая” гэсэн тушаалуудыг сахих гэсэн зүтгэл байхгүй мөртлөө “Эдгээж өгөөч” гэвэл хариулт авах боломжгүй юм. Тэр хугацаанд Бурханы хууль тушаалд дуулгаваргүй байснаа бүгдийг нь гэмшиж, үнэхээр Бурханыг хайрлаж, үгийн дагуу амьдарснаар эдгэрэх юм.

Дөрөвдүгээрт, Бурханы өмнө үйлдэж, суулгалгүй хураах гэсэндээ гэмших хэрэгтэй.

Эдгэрч хариулт авахын төлөө гуйвал тэр

хэмжээний Бурханы өмнө итгэлийн үрийг суулгах хэрэгтэй юм (Галат 6:7). Цаг хугацаа, зүтгэл, бүх зүйлээ зориулсан үр суулгах хэрэгтэй. Сүнсээр үнэнээр мөргөлд оролцож, залбирах ёстой бөгөөд Бурханы хаанчлалд үйлчлэх үрийг мөн суулгах ёстой ба мөн өргөл ч өргөх хэрэгтэй юм (Матай 6:21). Бурхан тэдний үйлсийг хараад хүлээн авах бус түүнд агуулагдах зүрх сэтгэлийн үнэрийг таалан авдаг. Итгэл болон бүх сэтгэлээр, хайрын үйлсээр Бурханыг баярлуулвал эдгэрэл болон хариултын үр нөлөө маш хурдан авах боломжтой. Онцгойлон хариулт авах зүйл байвал илүү их итгэмжит итгэлийн үр шаардагдах нь дамжиггүй.

2) Эзэн дотор сүнс талын итгэл олох хэрэгтэй

Угийн болон үйлдсэн гэм нүгэл огт байхгүй Есүс ташуурдуулан үнэт цусаа урсгаж өгсөн нь бидний гэмийг уучилж өгөхийн төлөө юм. Есүс ташуурдуулсанаар бид эдгэрсэн юм (Исаиа 53:5). Энэ үнэнд итгэдэг бол хэдийнэ хариулт авсан гэдэгтээ баттай байж, баяр хөөртэй, талархдаг байх хэрэгтэй юм. Яг энэ үед л хариулт авч чадах сүнс талын итгэл дээрээс өгөгддөг. Гэтэл хүн бүрийн хариулт авах цаг үе өөр байгааг харж харж болох юм.

Тус бүрийн зүрх сэтгэл ба нөхцөл байдлаас шалтгаалж, Бурхан өөрөөр нөлөөлдөг. Эдгэрсэний дараа хувиршгүй итгэлээр амьдрах хүн бол, одоо итгэл дутуу ч шууд эдгээж өгдөг бол, эсрэгээр нь итгэлээр өсөх тусам эдгэрэх үйл явц илрэх тохиолдол ч бий. Энэ нь Бурхан өвчнийг эдгээх нь гол зорилго бус харин сүнс сэтгэлийг нь аврахад л гол учир байгаа юм.

Түүнчлэн өвчнөөсөө эдгэрлээ гээд дахин гэмд хутгалдвал илүү ноцтой зүйл бий болж ч болзошгүй юм (Иохан 5:14). Хамгийн чухал нь эдгэрсэний дараа хувиралгүй Бурханы үгийн дагуу амьдрах хэрэгтэй юм. Ийм чин үнэн сэтгэлээр гуйх үед Бурхан хормын зуур хариулж өгөх боломжтой.

Хайрт итгэгч та бүхэн, Бурханы өвчин эдгээх хариулт, ерөөл авахаас илүү чухал зүйл нь бүх хүмүүсийг аврагдаж тэнгэрийн оронд орох явдал юм. Есүс Христийг хүлээн авч, гэмээсээ уучлагдан, Бурханы хүсч буй, сүнс талын итгэлийг авч бүх залбирал гуйлтдаа хариулт авч, төгс авралд хүрэхийг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

“Библид бүрэн тулгуурладаг, эдгэрэл болон гайхамшигт үйлс сэтгэл хөдлөм байлаа!”



Олег Острейко доктор (ОХУ, Мэдрэл, дотрын эмч)

Би Андрей Газировский докторын И Жей руг докторын амьдрал ба итгэлийн тухай илтгэл (Зураг 1) ээр маш их ивээл авсан юм. Үхлийн босгон дээр Бурхантай уулзсаны дараа маш амжилттай олон ажлуудыг хийж байгаа үнэхээр онцгой үйлчлэлийн тухай сонссон юм. Чин сэтгэлээр Бурханыг хайрлаж, Түүний үгийн дагуу амьдрахад ямар ерөөл авдаг болохыг болон, жинхэнэ итгэлийн амьдралын үлгэр жишээ болсон И Жей руг доктортоо баярлалаа.


Валери эмч (Украин)

Конференцд илтгэлээр тавигдсан эдгэрлийн гэрчлэлээр дамжуулан Бурханы эдгэрлийн хүч нөлөөг баттай харж ухаарал ивээл авсан цаг байлаа. Амьдрал дунд хүнд хэцүү асуудал тулгарах үед Бурханы хүчинд найдахад яаж ерөөгддөг болохыг харсан юм. Хэд хэдэн төрлийн баримтуудаас онцгойлон анхаарал татаж ивээл авсан гэрчлэл нь Давид Юу докторын “Амтат ус”-ны тухай танилцуулага байлаа (Зураг 2). Далай шорвог ус амтлаг болон хувирсан эрх мэдэлт хүчний нөлөө гарсан тухай үнэхээр гайхмаар бөгөөд библи дээр байдаг гайхамшигт тэмдэг тул илүү ивээлтэй байлаа.



“Бурхан бол амьд оршигч ба эдгээгч Эзэн юм!”

Польш улсын Варшав хотод WCDN (Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбоо)-ны 15 дах удаагийн олон улсын конференцд И Жей руг тэргүүн пасторын залбирлаар эдгэрсэн баримтуудыг дэлгэн тавьсан ба тус илтгэлүүдээр дамжуулан өнөө үед ч агуу хүч чадлаар нөлөөлж буй Бурхандаа алдрыг өргөсөн үйл явдал болсон юм.



Эдгэрлийн баримт 1 Тархинд цус харвалт

Доктор Любка Танчева
WCDN Болгари дахь захирал



И Ёон шим халамжлагч (56 нас, Солонгос) нь 15 өдрийн турш толгой өвддөг байсан ба 1 минут орчим биеийн бүх булчин татаж, чичирсэн байдаг. Тэгээд нүд нь эргэлдэж, зүүн тал саажсан байдалтай болж, ухаангүй болсон юм. СТ зурагны хариу нь их тархины өмнөд хэсгийн үзүүр буюу магнай хэсэгт цус харвалт явагдсан тухай харагдаж байсан бол дараагийн өдөр MRI зургын хариу нь магнай хэсэгт цус харвалт явагдсан төдийгүй баруун тархинд зарим хэсэгт ч цус харвалт болсон тухай олж мэдсэн юм.

2005 оны 4-р сард цус харваад 3 хоногын дараа сэхээн амьдруулах тасагт хэвтэж байгаа түүний төлөө гэрийнхэн нь өмнөөс нь И Жей руг пасторын залбирал авахад бага багаар ухаан орж эхлэн, хоёр дах удаа залбирал авахад зүүн талын саажилт тавирсан бөгөөд гуравдах удаа залбирал авахад хөл босч явдаг болж, гараараа юм атгах боломжтой болсон юм.

2 долоо хоногын дараа 5-р сарын 4ны өдөр авсан MRI зурганд харвалт өгсөн судасны бөөгнөрлийн хэмжээ багасч, тархины эргэн тойронд хэвийн байдалдаа орж байгаа нь харагдсан юм. Түүнээс хойш 9сарын дараа дахин СТ зураг авахуулахад бөөгнөрөл байхгүй болсон бөгөөд уйланхай юм уу шохойжилт байхгүй хэвийн болсон нт харагдаж байлаа.

MRI зураг



▲ Их хэмжээний цус харвалтын улмаас уураг тархины харагдаж байдал, залбирал авсаны дараах байдал

Лида Колесова эмч (Эстони, цацраг туяа рентгэнч)

“Би тархинд цус харвасан хүн эдгэрсэн тухай сонсоод маш их сэтгэл хөдөлсөн билээ. Учир нь Бурхан эдгээсэн болохоор. Цус харвсан өвчтөн яаралтай тусламж авахаар эмнэлэгт очсон ч залбирал авсаны дараа хэдэн хоногын дараа цус харвалтын шинж бүрэн арилсан юм. Энэ бол залбирлаар дамжуулан Бурханы хүч нөлөө гэж тайлбарлахаас өөр аргагүй юм. Тархины цус харвалт гэдэг маш ноцтой өвчин бөгөөд бүрэн эмчлэгдэж чадахгүй бол бие саажиж өдөр тутмын амьдралд их хэмжээний хүндрэл авчирдаг. Ерөнхийдөө ийм тохиолдолд яаралтай хагалгаанд орсоноор хэвийн болох боломжтой ч энэ тохиолдол нь зөвхөн залбирлаар Бурханы хүчээр төгс эдгэрсэн болохыг харж болох юм. Эзэндээ алдрыг өргөө.”



Эдгэрлийн баримт 2 Зүрхний шигдээс

Бахе Буниатан доктор
WCDN Армени дахь захирал



Татьяна Табанару итгэгч (57 нас, Молдав) нь зүрхний шигдээс болон элэг томролттой, мөн уушгины сүрьеэ өвчний улмаас үүдсэн уушгиний цусан хангамж дутмагшилаас болж хоёр хөл хавагнах, мөн дотуур хавагнасан байдлаас болж амьсгалахад ч хэцүү байдалтай байлаа. Эмч хэлэхдээ зүрхний зүүн тал өөхөлсөний улмаас хэвийн ажиллагаа алдагдаж, тохирсон эмчилгээ хийлгэхгүй бол 2 долоо хоногийн настай гэсэн байдаг.

Түүний хүү нь И Жей руг пасторын залбирал авах хүсэлт илгээж, 2014 оны 12-р сарын 24 ны өдөр И Жей руг пастор мөргөлийн дараа өвчний төлөө залбирал хийхдээ энэ итгэгчийн нэрийг дуудан залбирч өгсөн бөгөөд энэ итгэгч уг мөргөлийг бичлэгээр үзэж залбирал авсан юм.Түүний дараахан ямар нэг бөглөрөөд байсан зүйл гарах болж, зүрх хэвийн ажиллаж байгаа нь мэдэгдэж сайн амьсгалдаг болсон юм. Дараагийн өдөр бүх биеийн хаван бууж, 2015 оны 1-р сарын 1н гэхэд хэвийн байдалд орсон юм. Тун удалгүй тэрээр чөлөөтэй алхдаг, болсон бөгөөд тэр ч байтугай гүйж хүртэл чаддаг болсон юм.

Залбирал авахын өмнө ба дараа




▲ Уушгины цусан хангамжын дутагдлаас болж бүх бие хавагнаж, амьсгалахад хэцүү байдалтай байсан ч цаг орон зай үл хамаарах залбирал аваад бүрэн эдгэрч хаван бууж, хэвийн болсон байдал

Борис Топор доктор (Молдав, биеийн бүтэц зүйч)

“Энэ баримт бол Бурханы хүчээр эдгэрсэн нь баттай гэрчлэл юм. Энэ эмэгтэй ямар нэг анагаах ухааны тусламжгүйгээр зөвхөн залбирлаар эдгэрсэн юм. Уушгины цусан хангамжын дутмагшил болон бүх биеийн хавангийн улмаас амьсгалахад бэрхшээлтэй болж, яг л чимээгүй үхэж байгаа хүн зөвхөн залбирлаар эдгэрсэн юм. Бүх биеийн хаван бууна гэдэг маш гайхалтай явдал юм. Биеийн бүтэц зүйн онолоор бол энэ бол амархан шийдэгдэх зүйл биш юм.

Илүү гайхалтай нь залбирал хийж өгсөн И Жей руг пастор Солонгост байгаа бол өвчтөн нь Европт Молдавт байгаад юм. Цаг орон зайг үл хамаарах залбирал аваад эдгэрсэн гэдэг нь үнэхээр Бурханы хүч нөлөө юм.”




Эдгэрлийн баримт 3 Цөсний чулуу

Даниел Пуеинтэс доктор
WCDN Мексик дахь захирал



Мариа Макуадо эгч дүү (24 нас, Перу) нь 2014 оны 9-р сард гэнэт гэдэс хэвлий хэсгээр өвдөж эхлэн эход үзүүлэхэд цөсөнд нь 16,5мм хэмжээтэй чулуу байгааг олж мэдсэн юм. Тэрээр итгэлээрээ эдгэрэл авахын төлөө өөрийгөө эргэн харан гэмшиж байхад И Жей руг пасторын залбирлаар эдгэрч чадна гэсэн бат итгэлтэй болсон юм. Түүний дараахан дахин эход харуултал 16,5мм хэмжээтэй чулуу алга болсон байлаа. Цөсний хүүдийнд ердийн хэмжээ нь 5мм ба үүнээс илүү том 16,5мм хэмжээтэй чулуу гарах боломжгүй байтал ийм явдал болсон юм.

Эхо зураг




▲ Залбирал авахын өмнө: Эхо зурганд цөсөн дахь 16,5мм чулуу байгаа нь
▶ Залбирал авсаны дараа: Зүүдэнд И Жей руг пасторын залбирал авсаны дараа цөсний чулуу алга болсон байдал

Ким Мүн сэн (59 нас, Солонгос)

нь 2017 оны 6-р сард гэнэт гэдсээр хүчтэй өвдсөн ба шинжилгээ хийлгэтэл цөсний хүүдийн үхжилт явагдаж буй хурц үрэвсэл болох нь тогтоогдсон юм. СТ зурагны хариу нь цөсний хүүдийн үрэвсэл нэлээн даамжирсан байдалтай, зарим хэсгээрээ үхжилт явагдан эргэн тойрондоо идээлсэн шинжтэй цусанд халдварлах үе шаттай болсон байв. Гэсэн ч итгэлээ үзүүлж И Жей руг пасторын залбирал авсаны дараа хэдийн үхжилт явагдсан цөсний хүүдий хэдийн байдалтай болж сэргэсэн юм.



СТ зураг



▲ Залбирал авахын өмнө: Цөсний хүүдийн үхжил эргэн тойрондоо идээлсэн байдал
▶ Залбирал авсаны дараа: Үхжсэн цөсний хүүдий залбирал аваад хэвийн болсон нь

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminnews@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин